



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 8/211

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрлөөр олгосон эрх хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 0066459 дугаартай шийтгэлийн хуудас, 2019 оны 2 дугаар сарын 25-ны 02-03/708 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нүүр амны их эмч Энхбилэгийн Самбарт ИЭ0023287 сери, 0023287 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 3 сарын хугацаагаар хассугай.

2. Э.Самбарын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрх хассантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг гурван сарын хугацаагаар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Амарсайхан/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо /Ч.Доржгүнсмаа/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчuluun/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



080840